



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Даланзадгад хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Аудитор: О.Чойдорж

Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
3.5.1 Төсвийн төлөвлөлт	Error! Bookmark not defined.
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	Error! Bookmark not defined.
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Албан шаардлага.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 446

танай _____-ны № _____-г

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ахмадын сангийн үлдэгдэл 30,371.4 мянган төгрөгийг Сангийн яам татан төвлөрүүлснийг авлагаар тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 5,371,247.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 5,157,259.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 261,152.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050370

IF 12 Өмнөговь аймгийн политехник коллежийн захирал Ч.Эрдэнэтуяа танаа

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан***(Төгрөгөөр)*

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	423,428,275.77	478,555,717.21
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		423,428,275.77	478,555,717.21
3121	Төгрөг		423,428,275.77	478,555,717.21
31211	Төрийн сангийн харилцах		423,428,275.77	478,555,717.21
33	АВЛАГА	5	-	30,371,451.00
335	Бусад авлага		-	30,371,451.00
3351	Байгууллагаас авах авлага		-	30,371,451.00
34	УРЬДЧИЛГАА		-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	6	529,420,448.74	407,920,873.68
351	Түүхий эд материал		239,306,392.98	124,795,365.60
35110	Тусгай зориулалттай материал		238,587,592.98	124,364,765.60
35130	Эм боох материал		718,800.00	430,600.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		24,972,000.00	20,743,100.00
354	Хангамжийн материал		264,902,055.76	262,382,408.08
35410	Бичиг хэргийн материал		6,545,984.00	6,418,000.00
35420	Аж ахуйн материал		151,405,276.76	136,737,704.08
35430	Сэлбэг хэрэгсэл		3,592,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал		168,300.00	-
35450	Барилгын засварын материал		10,431,300.00	12,398,834.00
35460	Хүнсний материал		60,000.00	2,790,000.00
35470	Бусад хангамжийн материал		92,698,695.00	104,037,870.00
35600	Мал амьтад		240,000.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА		-	-
1	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		952,848,724.51	916,848,041.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	4,804,258,781.32	5,249,349,592.98
392	Биет хөрөнгө		4,406,791,281.32	4,851,882,092.98
39201	Барилга, байгууламж, орон сууц		4,135,973,873.54	4,135,973,873.54
39202	Хуримтлагдсан элэгдэл		(655,703,199.35)	(750,845,843.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		364,209,837.30	379,209,837.30
39204	Хуримтлагдсан элэгдэл		(221,326,779.12)	(247,871,258.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		1,949,561,032.76	1,500,182,668.68
39206	Хуримтлагдсан элэгдэл		(1,456,952,502.21)	(531,796,694.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		288,039,928.28	283,012,204.10
39208	Хуримтлагдсан элэгдэл		(213,357,763.79)	(106,854,471.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө		54,649,468.28	54,479,468.28
39215	Хуримтлагдсан элэгдэл		(33,768,092.17)	(38,041,757.19)
39217	Ном		195,465,477.80	174,434,065.80
393	Биет бус хөрөнгө		397,467,500.00	397,467,500.00
39301	Програм хангамж		1,692,000.00	1,692,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,692,000.00)	(1,692,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		397,467,500.00	397,467,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,804,258,781.32	5,249,349,592.98
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,757,107,505.83	6,166,197,634.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	16,173,897.55	-
413	Өглөг		16,173,897.55	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		13,955,637.55	-
4136	Бусад өглөг		2,218,260.00	-

41361	Байгууллагад төлөх өглөг		2,218,260.00	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,173,897.55	-
51	Засгийн газрын хувь оролцоо		5,740,933,608.28	6,166,197,634.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,919,946,942.70	1,919,946,942.70
512	Хуримтлагдсан үр дүн		3,432,059,596.06	3,857,323,622.65
51210	Өмнөх үеийн үр дүн		3,432,059,596.06	3,432,059,596.06
51220	Тайлант үеийн үр дүн		-	425,264,026.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		388,927,069.52	388,927,069.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,740,933,608.28	6,166,197,634.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,757,107,505.83	6,166,197,634.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,912,001,570.00	5,787,006,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,972,971,700.00	5,371,247,770.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,972,971,700.00	5,371,247,770.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		635,991,170.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		243,301,137.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		392,690,033.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		303,038,700.00	415,758,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		303,038,700.00	415,758,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		971,819,338.06	1,707,273,711.83
120	Нийтлэг татварын бус орлого		971,819,338.06	1,707,273,711.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		583,751,430.06	1,089,267,756.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		577,056,979.06	483,271,590.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,694,451.00	605,996,166.00
120009	Бусад орлого		-	29,972,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		377,706,958.00	571,531,044.21
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		10,360,950.00	16,502,911.62
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	5,883,820,908.06	7,494,280,081.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,246,386,045.07	7,047,984,643.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,075,556,535.53	6,732,085,571.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,229,571,465.99	4,439,749,701.29
210101	Үндсэн цалин		1,533,704,531.81	1,743,531,453.16
210102	Нэмэгдэл		1,199,717,415.13	2,081,797,743.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт		144,503,030.00	166,494,900.00
210104	Урамшуулал		351,646,489.05	447,925,604.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		399,284,487.01	546,388,366.72
210201	Тэтгэврийн даатгал		279,140,040.79	372,608,971.03
210202	Тэтгэмжийн даатгал		31,602,830.55	44,060,871.42
210203	ҮОМШӨ-ний даатгал		15,494,417.16	21,998,805.35

210204	Ажилгүйдлийн даатгал		14,428,859.00	21,490,451.68
210205	Эрүүл мэндийн даатгал		58,618,339.51	86,229,267.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		209,600,190.46	346,587,328.55
210301	Гэрэл, цахилгаан		47,426,567.23	88,593,296.66
210302	Түлш, халаалт		126,676,791.23	217,686,911.73
210303	Цэвэр, бохир ус		35,496,832.00	40,307,120.16
2104	Хангамж, бараа материалын зардал		34,486,487.95	-
210401	Бичиг хэрэг		7,228,760.00	-
210402	Тээвэр, шатахуун		6,680,721.80	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,577,006.15	-
2105	Нормативт зардал		122,732,550.00	197,369,595.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		628,300.00	-
210502	Хоол, хүнс		122,104,250.00	197,276,495.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		-	93,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		132,796,920.00	10,753,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		38,480,420.00	8,798,700.00
210604	Урсгал засвар		94,316,500.00	1,954,800.00
2107	Томилолт, зочны зардал		14,257,680.00	-
210701	Гадаад албан томилолт		14,257,680.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-	104,461,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	104,461,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		932,826,754.12	1,086,776,080.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		308,419,539.79	450,708,575.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		304,152,908.00	376,318,684.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		320,254,306.33	259,748,820.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		170,829,509.54	315,899,071.45
2132	Бусад урсгал шилжүүлэг		153,241,600.00	248,682,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		-	102,576,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		68,780,000.00	140,506,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		84,461,600.00	5,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		17,587,909.54	67,216,471.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		17,587,909.54	67,216,471.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-
2200	Дотоод эх үүсвэрээр		-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	5,246,386,045.07	7,047,984,643.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		637,434,862.99	446,295,438.59
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	21,031,412.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-	21,031,412.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-	(21,031,412.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		637,434,862.99	425,264,026.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,495,753,000.06	6,906,246,126.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	583,751,430.06	1,119,239,756.00

120	Нийтлэг татварын бус орлого	583,751,430.06	1,119,239,756.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	583,751,430.06	1,089,267,756.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	577,056,979.06	483,271,590.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,694,451.00	605,996,166.00
120009	Бусад орлого	-	29,972,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,912,001,570.00	5,787,006,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,972,971,700.00	5,371,247,770.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,972,971,700.00	5,371,247,770.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	635,991,170.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,301,137.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	392,690,033.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	303,038,700.00	415,758,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,038,700.00	415,758,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,989,750,564.29	6,696,778,684.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,989,750,564.29	6,696,778,684.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,818,921,054.75	6,350,508,162.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,214,277,582.53	4,453,705,338.84
210101	Үндсэн цалин	1,533,704,531.81	1,757,487,090.71
210102	Нэмэгдэл	1,184,423,531.67	2,081,797,743.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	144,503,030.00	166,494,900.00
210104	Урамшуулал	351,646,489.05	447,925,604.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	400,921,985.37	546,388,366.72
210201	Тэтгэврийн даатгал	280,777,539.15	372,608,971.03
210202	Тэтгэмжийн даатгал	31,602,830.55	44,060,871.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,494,417.16	21,998,805.35
210204	Ажилгүйдлийн даатгал	14,428,859.00	21,490,451.68
210205	Эрүүл мэндийн даатгал	58,618,339.51	86,229,267.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,600,190.46	346,587,328.55
210301	Гэрэл, цахилгаан	47,426,567.23	88,593,296.66
210302	Түлш, халаалт	126,676,791.23	217,686,911.73
210303	Цэвэр, бохир ус	35,496,832.00	40,307,120.16
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	114,273,500.00	200,179,022.00
210502	Хоол, хүнс	109,598,500.00	200,179,022.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,675,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,157,000.00	45,181,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	59,306,400.00	43,226,600.00
210604	Урсгал засвар	83,850,600.00	1,954,800.00
2107	Томилолт, зочны зардал	14,257,680.00	-
210701	Гадаад албан томилолт	14,257,680.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	104,461,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	104,461,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	722,433,116.39	654,005,706.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	286,747,638.39	335,913,278.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	435,685,478.00	318,092,428.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,829,509.54	346,270,522.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,241,600.00	248,682,600.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	102,576,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	68,780,000.00	140,506,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	84,461,600.00	5,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	30,371,451.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	30,371,451.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,587,909.54	67,216,471.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,587,909.54	67,216,471.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	506,002,435.77	209,467,441.44
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	82,574,160.00	154,340,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,574,160.00	154,340,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	82,574,160.00	154,340,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	82,574,160.00	154,340,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(82,574,160.00)	(154,340,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	423,428,275.77	55,127,441.44
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		423,428,275.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	423,428,275.77	478,555,717.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,919,946,942.70	388,927,069.52	3,432,059,596.66	5,740,933,608.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	425,264,026.59	425,264,026.59
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,919,946,942.70	388,927,069.52	3,857,323,622.65	6,166,197,634.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,024,793,300.00	5,719,789,898.55
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,420,571,100.00	5,371,247,770.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,420,571,100.00	5,371,247,770.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	604,222,200.00	348,542,128.55
132001	Орон нутгийн төсвөөс	604,222,200.00	348,542,128.55
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,089,267,756.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	483,271,590.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	605,996,166.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,024,793,300.00	6,389,029,654.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,024,793,300.00	6,783,902,213.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,772,884,700.00	6,504,848,162.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,956,291,300.00	4,453,705,338.84
210101	Үндсэн цалин	2,395,403,200.00	1,757,487,090.71
210102	Нэмэгдэл	1,384,393,200.00	2,081,797,743.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,494,900.00	166,494,900.00
210104	Урамшуулал	-	447,925,604.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	494,536,500.00	546,388,366.72
210201	Тэтгэврийн даатгал	336,284,800.00	372,608,971.03
210202	Тэтгэмжийн даатгал	39,562,900.00	44,060,871.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,781,500.00	21,998,805.35
210204	Ажилгүйдлийн даатгал	19,781,500.00	21,490,451.68
210205	Эрүүл мэндийн даатгал	79,125,800.00	86,229,267.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	602,222,200.00	346,587,328.55
210301	Гэрэл, цахилгаан	85,627,000.00	88,593,296.66
210302	Түлш, халаалт	455,136,000.00	217,686,911.73
210303	Цэвэр, бохир ус	61,459,200.00	40,307,120.16
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	237,345,300.00	200,179,022.00
210502	Хоол, хүнс	237,345,300.00	200,179,022.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,066,600.00	45,181,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,066,600.00	43,226,600.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,954,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,461,000.00	104,461,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,461,000.00	104,461,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,961,800.00	808,345,706.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,482,200.00	373,235,078.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	204,479,600.00	435,110,628.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,908,600.00	248,682,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	251,908,600.00	248,682,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	102,576,600.00	102,576,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	149,332,000.00	140,506,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,600,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	6,024,793,300.00	6,783,902,213.11
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		423,428,275.77
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		478,555,717.21

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,209,522.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,209,522.2 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Бараа материалын тодруулга тайлангийн бусдаар авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материалын дүнтэй тулган баталгаажуулахад 443.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 513.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнтэй тулган баталгаажуулахад 89,259.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайлангийн хоол, хүнсний зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 67,527.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого, туслах үйл ажиллагааны орлогыг 1,119,239.7 мянган төгрөгийг бөөн тайлагнасан
- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй байна

Аудитаар нийт 43,177.2 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 27,878,2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 15,299.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тайлант онд Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, няравт нийт 5,669.5 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2025 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан *"Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"*-тай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 2. Тус коллежийн албан хаагчийн харилцах данс руу уралдаан тэмцээнд бэлтгэхэд зориулж 5,428.7 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.2-д *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т *"анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*, 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Илрүүлэлт 3. Гэрээ байгуулалгүй хувь хүнээс нийт 16,780.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Илрүүлэлт 4. Тайлант онд 4,499.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 10,800.0 macbook тус тус худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тодруулга тайлангийн бусдаар авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материалын дүнтэй тулган баталгаажуулахад 443.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	443.0			1	443.0	1	443.0				
2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй байна	1	0.0			1	0.0	1	0.0				
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 513.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	513.0			1	513.0	1	513.0				
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнтэй тулган баталгаажуулахад 89,259.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	89,259.0			1	89,259.0	1	89,259.0				
Мөнгөн гүйлгээний тайлангийн хоол, хүнсний зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 67,527.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	67.2			1	67.2	1	67,257.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого, туслах үйл ажиллагааны орлогыг 1,119,239.7 мянган төгрөгийг бөөн тайлагнасан	1	1,119,239.7			1	1,119,239.7	1	1,119,239.7				
Дүн	6	1,209,522.3			6	1,209,522.3	6	1,209,522.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус коллежийн албан хаагчийн харилцах данс руу уралдаан тэмцээнд бэлтгэхэд зориулж 5,428.7 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн	1	5,428.7			1	5,428.7						
Гэрээ байгуулаагүй хувь хүнээс нийт 16,780.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн	1	16,780.0			1	16,780.0						
Тайлант онд Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, няравт нийт 5,669.5 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон	1	5,669.5			1	5,669.5						
Тайлант онд 4,499.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 10,800.0 мянган төгрөгийн тасbook тус тус худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	15,299.0					1	15,299.0				
Дүн	4	43,177.2			3	27,878.2	1	15,299.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ДҮН								